



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2018 оны 11 сарын 20 өдөр

Дугаар А/425

Улаанбаатар хот

Төгсөлтийн дараах үндсэн мэргэшлийн  
сургалтад суралцуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дах хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.9, Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/337 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон давтан сургалт явуулах, зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох журам", Эрүүл мэндийн сайдын 2018 оны А/429 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "2018-2019 оны хичээлийн жилд эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах үндсэн мэргэшлээр суралцуулах хяналтын тоо", Эрүүл мэнд, спортын сайд, Сангийн сайдын "Журам батлах, зардлын жишиг тогтоох тухай" 2015 оны 97/56 дугаар хамтарсан тушаал, Баян-Өлгий аймгийн Эрүүл мэндийн газрын даргын 2018 оны 612 тоот албан бичиг, резидент эмч Б.Базарбидрэн, Х.Айнур нарын хүсэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хавдар судлалын үндэсний төвийн "Хавдар судлал" үндсэн мэргэшлийн сургалтын 2 дугаар дамжааны резидент эмч Бат-Эрдэнийн Базарбидрэнг Цэргийн төв эмнэлгийн "Мэс засал судлал" үндсэн мэргэшлийн сургалтын 1 дүгээр дамжаанд шилжүүлэн суралцуулсугай.
2. Улсын гуравдугаар төв эмнэлгийн "Дотрын анагаах судлал" үндсэн мэргэшлийн сургалтын 2 дамжааны резидент эмч Хабсеметийн Айнурьг 2018-2019 оны хичээлийн жилд улсын төсвийн санхүүжилтээр суралцуулахыг Эрүүл мэндийн хөгжлийн төв /Д.Ганцэцэг/-д зөвшөөрсүгэй.
3. Б.Базарбидрэн, Х.Айнур нарын үндсэн мэргэшлийн сургалтыг холбогдох журмын дагуу зохион байгуулахыг Эрүүл мэндийн хөгжлийн төв /Д.Ганцэцэг/, сургалт эрхлэх байгууллагын дарга, захирал нарт тус тус үүрэг болгосугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн дарга /Э.Содномжамц/-д даалгасугай.

САЙД

Д.САРАНГЭРЭЛ